

Дунд сургуулийн музейн үзүүлэлэг зохион байгуулах нь

Музей нь тухайн орны нийгэм соёлын хөгжлийн толь байдаг билээ. Дунд сургуулийн музейн үзүүлэлэг зохион байгуулахад анхаарах арга зүйн зөвлөмжийг ОХУ-ын музей судлаачдын бүтээлээс орчуулан Та бүхэнд толилуулж байна.

Музейн үзүүлэлэг гэдэг нь тухайн музейн сонгосон сэдвийг дэлгэн харуулах зорилгоор музейн эд өлгийн зүйлийг, өнгө төрх, донж маягийг тохируулан тодорхой дэс дарааллаар толилуулсан цогц нэгдэл юм.

Сургуулийн музейн үзүүлэлэг нь харагдах байдлаараа босоо болон хэвтээ гэсэн хоёр төлөвтэй байдаг. Босоо төлөвтэй үзүүлэлэг нь үзэхэд илүү тохиромжтой байдаг.

1. Босоо шугамын дагуу хананд байрлуулсан үзмэрийн самбар, планшет-зураглалын тогтоогчтой самбар болон ханын хоргонд танин мэдэхүй, хүмүүжлийн ач холбогдолтой хамгийн гол үзмэрүүдийг байрлуулна.

2, Хэвтээ шугам дахь хорго, тавиур, ширээний үзмэрүүд нь босоо шугамын дагуух үзмэрүүдэд нэмэлт болж, мэдээллийг гүнзгийрүүлж өгнө.

Далд төлөвлөлт буюу далд үзүүлэлэгийн аргуудыг үзмэр дэглэхэд ховорхон ашигладаг. Энэ төрөлд эргүүлж үзэх хавтсан самбар, шургуулга хэлбэрийн самбар, сөхөж үзэх самбар, зургийн цомог зэрэг багтана. Тухайн аргаар байрлуулсан үзмэр нь нүднээс далд байдаг боловч бага орон зайнд олон тооны үзмэр, баримт бичиг багтдаг давуу талтай.

Үзмэрүүдийг байрлуулахдаа дараах ерөнхий дүрмийг баримталдаг. Үүнд:

1. Том хэмжээтэй зураг болон үзмэрийг холбож өгдөг танилцуулга бичгийг үзүүлэлэгийн үндсэн шугамын дээд хэсэгт, заримдаа түүний дээр байрлуулдаг.

2. Үзэгчдэд сайн харах боломж олгохын тулд жижиг үзмэр болон гэрэл зураг, баримт бичиг зэргийг хүний нүдний харааны түвшинд байрлуулдаг.
3. Үзүүлэгийн танхимын үзэгчийн нүдэнд хамгийн түрүүлж тусах хэсэгт агуулгын хувьд хамгийн чухал үзмэрийг байрлуулна. Энэ хэсэг танхимын талбайн хэвтээ тэнхлэгийн дээд хэсэгт орших агаад үзэгчдийн анхаарлын 60 хувийг шууд татдаг.

Үзэсгэлэн дэглээч нь тухайн ханыг үзмэрийн самбар, хоргоор дүүргэх, тэнхлэгийн тэгш хэмийг баримтлах зарчимд баригдахгүй, бүлэглэн зохион байгуулсан үзмэрүүд нэгэн цул болж харагдахаар тодорхой системтэй байрлуулах ёстой.

Үзүүлэгийн харилцан хамааралтай хэсгүүдийн цогц үзүүлэгийн сэдэвчилсэн бүтцийг бүрдүүлдэг. Сэдэвчилсэн бүтцийн дагуу үзүүлэгийн материалуудыг бүлэглэнэ. Бүлэг тус бүрийг үзүүлэгийн иж гэж нэрлэх бөгөөд энэхүү иж үзүүлэг нь сэдэв болон харагдах байдлаараа нэгэн бүхэллэг болж, тодорхой хязгаарлагдсан талбайд байна.

Үзүүлэгийн агуулга нь үзэсгэлэнгийн цогцолборын уран сайхны дүр болон арга хэрэгслийг тодорхойлдог.

Эх орны дайны тухай үзэсгэлэн нь харилцан адилгүй хэмжээ, хэлбэртэй хэд хэдэн самбараас бүрдэж болно. Учир нь үзэсгэлэнгийн самбарын хэлбэр, хэмжээ нь тухайн үзүүлэгийн агуулгыг илэрхийлэх нэг гол арга хэрэгсэл юм. Үзүүлэгийн самбарын тэгш гадаргуйг бөмбөгдөлтөнд өртсөн мэт болгосноор тэр эмгэнэлт он жилүүдийг харуулдаг. Хамар гаргасан самбарууд нь бэхлэлтийн шонг санагдуулна.

Үзүүлэгт дүрслэгдэх сэдэв уран сайхны дэглэлтийн тодорхой арга хэрэгслийг тодорхойлдог. Жишээ нь: “Фашизмын нүүр царай” үзэсгэлэнгийн орон зайг нарийхан харанхуй, “мухар” гудамж мэт хийнэ. Үзэгчийн нүдэнд хар, хүрэн болон зэвэрсэн зэвхий хана, хурц өнцөг, булан тохой өртөнө. Үүний тулд зэвэрсэн төмөр, өргөст тор, шатсан модыг ашиглана.

Ямар нэгэн цэргийн анги нэгтгэлийн дайчин замналын талаар үзүүлэгийг хэд хэдэн самбарт хийж болно. Эхний самбарт Эх орны

дайны эхнээс ч юм уу, эсвэл уг анги нэгтгэлийн байгуулагдсан цагаас ялалт хүртэлх замналыг газрын зураг дээр дэлгэрэнгүй тайлбарын хамт тавина. Дараа дараачийн самбарт тухайн ангийн нэгтгэлийн алдартай тулалдаан, нууц ажиллагааг дайчдын гэрэл зураг, захидал, баримт бичиг зэргээр харуулна. Самбар бүрийг дэд сэдвүүдэд хувааж, текст, үзмэрийн тайлбарыг бичнэ. Текстэд ангийн тулалдаан, баатруудын талаар өгүүлнэ. Хэрэв тулалдаан музей оршиж байгаа нутагт болсон бол их анхаарал хандуулна.

Үзэсгэлэнгийн хэвтээ шугамын дагуух хоргонд цэрэг офицеруудын хувийн эд зүйлс, захидал ба одон медалийн хуулбар зэргийг дэлгэн үзүүлнэ. Холбох текст нь хөтлөх болон нэгтгэх текст гэсэн хоёр хэсгээс бүрдэнэ. Хөтлөх текст гэдэг нь баримт бичгийн хэсэг, дурсамж болон уран зохиолын номноос авсан эшлэл байдаг. Хөтлөх текстийг самбарын дээд хэсэгт буюу шаардлагатай бол хаана ч байрлуулж болох бөгөөд үзүүллэгийн гол үзэл санааг тусгадаг Нэгтгэх текст нь үзүүллэгийн гол хэсгүүдийн сэдвийн талаар ерөнхий ойлголт өгөх ба самбарын баруун дээд буюу зүүн талд байдаг. Жишээлбэл, хэрэв ямар нэг баатрын талаар өгүүлж буй бол нэгтгэх текстэд байгаа тохиолдолд нэгтгэсэн текст нь тухайн баататүүний намтрыг өгнө:

Николай Петрович Попов
(1918-1998)

Багшийн гэр бүлд төрсөн. Осиновын дунд сургууль болон Сталинградын Багшийн дээд сургуулийг төгссөн. 1941 онд цэрэгт татагджээ. Брестийн цамхагийн хамгаалалт, Сталинградын тулалдаан, Украин, Польшийн чөлөөлөлт, Берлиныг авах довтолгоонд оролцсон. Дайны дараа Осиновын дунд сургуулийн багш, улмаар захирлаар нь ажиллаж байв. Олон шагнал хүртсэн.

ҮЗҮҮЛЛЭГ ЗОХИОН БАЙГУУЛАХ АЖИЛ

Үзүүллэг зохион байгуулахын тулд доорх нөхцөлийг бүрдүүлсэн байх шаардлагатай. Үүнд:

1. Музейн сан хөмрөгтөө тухайн сэдэвт хамаарах үзмэртэй байх. Мөн гаднаас нэмэлт үзмэр, материал цуглуулж болно.

2. Төлөвлөсөн сэдвийн асуудлыг мэддэг, үзүүллэг зохион байгуулах арга зүйг эзэмшсэн үзэсгэлэн зохион байгуулах баг бүрдүүлэх.
3. Үзүүлэг дэглэх зориулалтын байр бэлтгэх.

Үзүүллэгийн эхний ажил нь түүхэн сэдвийн эрдэм шинжилгээний судалгааны ажлын анхан шатны ажилтай адилхан. Үүнд:

1. Тухайн үзүүллэгийн сэдэвт хамаарах ерөнхий болон тухайн сэдвийн эрдэм шинжилгээны ном зохиолын жагсаалт гаргаж, тэдгээрийг судлах. Ингэхдээ тэмдэглэл хөтөлж, ном зохиол, өгүүллийг эшлэн заах, тухайн сэдвээр мэргэшсэн судлаачдын зөвлөлгөө авах,

2. Сэдвийн холбогдох эх сурвалжтай танилцах. Үүнд: сургуулийн музейн сан хөмрөг болон бусад музей, номын сан, архив зэрэг.

Судалгааны үр дүнд үзүүллэгийн үзэл баримтлал буюу онол - үзэл санааны үндэслэл, үзүүллэгийн утга санаа гарна. Үзүүллэгийн утга санааг бичихдээ зохиогчид нь үзэсгэлэнгийн зорилтуудыг тодорхойлж, үндсэн сэдэв болон дэд сэдвүүдийг томъёолно. Үндсэн болон дэд сэдвүүдийн агуулга музейн сан хөмрөгт тухайн сэдвээр байгаа үзмэрүүдийн тухай товч бичнэ. Үзүүллэгийн утга санаа нь цаашид ном зохиол, архивын материал судлах хөтөлбөр болно.

Үүний тул сэдэв, дэд сэдэв нэг бүрийн ард хамрагдах асуудлууд, тэдгээрийг дэлгэн харуулахад чухал шаардлагатай үзмэрийн жагсаалтыг хийж өгнө. Ингээд нэмж цуглуулга хийх эсэхээ шийднэ. Үзүүллэгийн утга санаагаа хийсний дараа гаргах үзэсгэлэнгийнхээ сэдэвчилсэн бүтэц буюу тодорхой, дэлгэрэнгүй төлөвлөгөөг хийнэ.

ҮЗҮҮЛЛЭГ ЗОХИОН БАЙГУУЛАХ ЕРӨНХИЙ ЗАРЧМУУД

1. **Тодорхой үзэл баримтлал- концепцийн дагуу зохион байгуулах** - зохион байгуулж буй үзүүллэгтээ зөвхөн тухайн сэдэв, үзэл санааны дагуу үзмэрээ сонгох,

2. **Түүхэн зарчим** - үзэгдэл, үйл явдал хэрхэн үүсч, өрнөсөн, ямар үе шат дамжсан болон одоо болсныг харуулах, Тухайлбал,

Хэрэв Эх орны дайны баатрын тухай өгүүлж байгаа бол түүний амьдралыг өнөөдрийн өдөр хүртэл буюу нас барах хүртэл нь өгүүлнэ.

3. Эд өлгийн зүйлээр харуулах зарчим – музейн үзмэр тухайн үйл явдлыг гэрчлэх баримт, төдийгүй зарим тохиолдолд сэтгэл хөдөлгөх мэдээллийн тээгч байдаг тул үзэгчдэд сонирхол төрүүлэхгүй үзмэрийг дэлгэн үзүүлэх шаардлагагүй.

4. Үзэгчдэд хүргэх зарчим – Үзүүлэгийг бүх насны үзэгчдэд хүрэхүйц байхаар бодолцож дэглэхийг хэлнэ. Үзүүлэг ахлах ангийнханд ч бага ангийнханд ч ойлгомжтой байх хэрэгтэй.

ҮЗҮҮЛЛЭГИЙН СЭДЭВЧИЛСЭН ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛАХ

Музейн үзүүлэгийн бүтцийг дараах байдлаар хуваадаг бөгөөд энэ нь сургуулийн музейд ч хамааралтай Үүнд:

- Үзүүлэгийн хэсгүүд
- Хэсэг бүрийн доторх сэдвүүд, заримдаа дэд сэдэв
- Сэдэв буюу дэд сэдэв нь үзүүлэгийн цогц хэсгүүдээс бүрдэнэ.

Үзүүлэг ийн сэдвүүд ийн нэр	Д\д	Үзмэрийн төрөл, эх үзмэр мөн эсэх, хэмжээ, жин	Үзэсгэлэнги йн агуулга, нэр, нэр, он цаг	Сан хөмрөг дэх байршил, үзмэрийн дугаар	Үзүүлэгт байрлах байр	Тайлбар
Дэд сэдэв 1. Сталинград хотын дэргэд германы фашисту	1	Текст	Зөвлөлтийн ард түмэн Баатар хот Сталинград ын дэргэд дэлхийн түүхэнд		Үзмэрийн заалан дахь текст	

удыг бут цохисон үр дүн			тэмдэглэгдэх агуу ялалт байгуулснаар Дэлхийн II дайны явцыг фашизмын эсрэг эвсэлд нэгдсэн ард түмэн, улс орруудад ашигтайгаар эргүүлж чадсан юм. (Дэлхийн II дайны түүх 1939-1945он. М., 1976 он. боть 6.тал.82)			
	2	Гэрэл зураг 5x2м	Сталинградын дайнда амь үрэгдсэн дайчдын гэгээн дурсгалд зориулсан талбай дахь цуглаан 1943 оны II сарын 4.	Хальс 3163	Ханан дахь том зураг	
	3	Баримт бичиг /эх	Сталинград ялсан нь	үзмэрийн дугаар	Хорго 2	

		үзмэр/ 21x41 см	/ухуулах хуудас/ 1943оны II сарын 4.	297 тавиур 284		
	4	Биет үзмэр. урт нь 24.8см	Буудлагын 214 ангийн найрал хөгжмийн цан	Үзмэрийн дугаар 7797 шүүгээ 7 тавиур1	1 хорго	
	5	Зурагт хуудас /эх үзмэр/ 40x30см	“Сталинград ” 1942он. /зураач В.Н.Денисов , Н.А. Долгоруков нар/	Үзмэрийн дугаар 1190. тавиур 2	1 хорго	

Сэдэвчилсэн төлөвлөгөөний нүүр хуудсанд музейн бүтэн нэр, үзэсгэлэнгийн нэр, сургуулийн дугаар, төлөвлөгөөг хийсэн ажилтны нэр овог, хийсэн он сар өдрийг тавина. Төлөвлөгөөний эхэнд, хуудасны дээд хэсэгт үзэсгэлэнгийн хэсэг, сэдвийн нэрүүдийг тодорхой бүтнээр нь бичнэ.

Нэгдүгээр мөр: Дэд сэдвүүдийн нэр - үзүүллэгийн дэд сэдвүүдийн нэр бичигдэнэ.

Хоёрдугаар мөр: Дэс дугаар - үзэсгэлэнгийн хар зураг гаргахад үзмэрийн нэрийг бүтнээр бичихээс илүүтэй дэс дугаарыг бичих нь амар хялбар байдаг.

Гуравдугаар мөр: Үзмэрийн төрөл, эх үзмэр эсэх, хэмжээ-
үзмэрийн төрөл: гэрэл зураг, баримт бичиг, биет үзмэр, зурагт хуудас, зураг

Үзмэрийн хэмжээг дараах дэс дарааллаар бичнэ: өндөр, өргөн, урт, диаметр

Эх үзмэр эсэх: эх үзмэр, хуулбар, гэрэл зургийн хувь, шуумал,
Дөрөвдүгээр мөр: Үзмэрийн агуулга - үзмэрийн товч бөгөөд тодорхой нэр, хэрэглэгдэж байсан он цаг

Тавдугаар мөр: Үзмэрийн байршил - үзмэрийн дугаар, зургийн хальсны дугаарыг заахдаа үзмэрийн байршилыг тодорхой бичнэ. Үүнд: шүүгээ, тавиур, хавтас, хайрцаг, цомог зэргийн дугаарыг заавал бичнэ.

Зургаадугаар мөр: Үзүүлэг дэх байршил – үзмэрийг үзэсгэлэнд байршуулах хорго, самбар, шүүгээ, хана, шал, тавиур г.м. зааж өгнө.

Долоодугаар мөр: Тайлбар – тухайн үзмэрийг үзэсгэлэнд тавихад бэлэн эсэх, сэргээн засварлах шаардлагатай бол чухам юу хийх шаардлагатайг нарийн бичнэ. Үүнд наах, цэвэрлэх, нөхөөс хийх, будах, зэвийг арилгах. Мөн зарим үзмэрийн хуулбар болон шуумал хийлгэх, өөр үзэсгэлэнгээс татаж авах хэрэгтэй эсэхийг энд бас бичнэ.

Сэдэвчилсэн төлөвлөгөөг боловсруулахдаа үзүүлэгийн сэдэв ба цогц хэсэг бүрийн үзмэрийн картууд хийнэ.

ҮЗҮҮЛЛЭГ ЗОХИОН БАЙГУУЛАХАД ГАРДАГ НИЙТЛЭГ АЛДАА

1. Үзүүлэг зохион байгуулахдаа зай тайлбайг бүрэн дүүрэн ашигладаггүй, нөгөө талаас талбай хэмнэдэггүй нийтлэг алдаа ажиглагддаг.
2. Үзмэр болон бичмэл материалыг хэт их шаваж, олноор нь нэг газар тавьдаг.
3. Сэдэв болгоныг цөөн үгээр, товч тодорхой илэрхийлж болдгийг анхаардаггүй, тайлбарын бичвэр нь хэт их нуршсан байх.
4. Тухайн үзмэрийн эргэн тойрон зай байх тусам уг үзмэрийг тодотгодгийг нарийн тооцоололгүй үзмэрээ дэглэдэг.
5. Түүхэн үйл явдалыг тусгасан, гэрчилж байгаа үзмэрүүдэд он цагийг тавилгүй орхигдуулах тохиолдол их байдаг. Ингэснээр уг үзмэрийн түүхэн үнэ цэнийг алдагдуулж байна гэдгээ төдийлөн бодолцдоггүйд гол алдаа нь оршдог.

6. Олон сараар – тухайлбал 6 сараас дээш бичиг баримт, гар бичмэл, захидал, уран зургийн эхийг дэлгэн үзүүлэх явдал нь үзмэрийн чанарт муугаар нөлөөлдөг. Тухайлбал: балын харандаа, бэх зэрэг нь бүдгэрч, цаас нь шарлаж гэмтдэг талтай. Иймд олон улсын жишигт ижил хэмжээтэй хулбар хийж үзүүлэлт тавьж, эх үзмэрийг тодорхой чийг, дулааны нөхцөл хангасан сан хөмрөгт хадгалах явдал түгээмэл байдаг.

Бэлтгэсэн: Д.Эрдмаа Арга зүйч